



**ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ
ХУВЬЦААТ КОМПАНИ**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
1 дүгээр хороо, Жигжиджавын гудамж 8, Финанс төв
Утас: 7505-5555
И-мэйл: info@erdenestt.mn, Вэбсайт: www.eit.mn

**ТЕНДЕРТ ОРОЛЦОХЫГ СОНИРХОГЧ
ЭТГЭЭДҮҮДЭД**

2024.05.13 № 01/823

танай _____-ны № _____-т

Тодруулгын хариу хүргүүлэх тухай

Тус компаниас 2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр зарласан ЭТТХК/20240101476 дугаартай “Цанхийн баруун уурхайн хөрс хуулалт, нүүрс олборлолт хийх ажил”-ын гүйцэтгэгчийг сонгох тендер шалгаруулалттай холбоотой ирүүлсэн тодруулгын хариуг хүргүүлж байна. Үүнд:

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль/шинэчилсэн найруулга/-ийн 14 дүгээр зүйлийн 14.5-д Гадаадын этгээд гадаад улсын банкнаас баталгаа гаргуулах тохиолдолд тендер шалгаруулалтын баримт бичигт заасан журмын дагуу тендерийн баталгааг хүргүүлнэ гэж заасан.

Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/252 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Худалдан авах ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох журам”-ын 4-т Гадаад улсын банк баталгаа гаргахад тавигдах шаардлагад тусгасны дагуу тендерийн баталгааг ирүүлнэ.

Гадаад улсын банкаар баталгаа гаргахдаа Монгол Улсад үүсгэн байгуулагдсан банк, санхүүгийн байгууллагаар дамжуулан цахим системд тендерийн баталгааг байршуулна. Тендерийн баталгааг цахим системээр гаргаагүй тохиолдолд тендер нээхгүй болно.

Мөн хуулийн 42.4-т Гадаад улсын банкнаас баталгаа гаргуулах эрхийг гадаадын этгээд эдлэх бөгөөд энэ тохиолдолд баталгаа гаргагчийн нэрийн өмнөөс захиалагчтай харилцах, мэдэгдэл хүлээн авах эрх бүхий этгээдээр Монгол Улсад үүсгэн байгуулагдсан банк, санхүүгийн байгууллагыг заасан байна гэснийг үндэслэн тендерийн баталгааг гаргах болохыг анхаарна уу.

**ЗАСГИЙН ГАЗРЫН ОНЦГОЙ
БҮРЭН ЭРХТ ТӨЛӨӨЛӨЧ**



Ж.ГАНБАТ